БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.МӨНХБАТ

2023 оны 11 дүгээр сарын 10

АЙМГИЙН ТӨВД АНГИЛАН ЯЛГАХ ХОГИЙН САВ, ДАХИВАР ЦУГЛУУЛАХ САВ БАЙРШУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Нэр	Үзүүлэлт
1	Ажлын зорилго, үндэслэл	Аймгийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан дахин боловсруулах хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын хэмжээг багасгаж орчны бохирдлыг бууруулах зорилгоор аймгийн төвийн орон сууцны хорооллуудад дахивар цуглуулах ангилан ялгах хогийн сав байршуулна.
	Байршил	Аймгийн төвийн орон сууцны хорооллууд /Ид шидийн оронд -1ш, Залуус хороололд 2ш, Холбооны 24-д 1ш, Хүнсний 48-д 1ш, Барилгын 48-д 1ш, Зах 1ш, Нэгдсэн эмнэлгийн ойролцоо 1ш, Багш нарын байр 1ш/, Ид шидийн орон хүүхэд хөгжил хамгааллын төвд дахивар цуглуулах ангилан ялгах хогийн сав байршуулж дахивар нөөц болох шил, лааз, хуванцар, гялгар уут зэрэг нийтлэг дахивар хог хаягдлыг Мандалын гэгээ хот тохижуулах газар, Баялаг төвөөс цуглуулж дахивар хүлээж авах цэгт нийлүүлнэ.
	Үндсэн хийц, материал	Гадаа нийтийн эзэмшлийн талбайд байршуулах учир байгалийн үзэгдлүүд цас, бороо, шороо салхи, хүний хэрэглээ, нөлөөлөлд элэгдэж муудахааргүй эдэлгээ сайтай чанартай галд тэсвэртэй материалаар хийж, хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн загвар хийцтэй байна. 1.2 мм-ээс багагүй зузаантай 3х2мм болон 4х2мм-ийн -ийн квадрат төмрөөр бэхэлгээ, хөндөл болон үндсэн араамыг зангидна. 4х4см-тэй төмөр тороор тасалгаа хийнэ Их бие 1мм-ээс багагүй зузаантай листэн төмрөөр бүрнэ.
	Хэмжээ	Өндөр 1.8 метр Урт 3 метр Өргөн 1.5 метр
	Бүтэц	Дахивар хийх 3 хэсэгтэй 1.Шил, лааз /улбар шар өнгөтэй Варений шил болон архины шилийн тавих тавиур бүхий/ 2.цаас /цэнхэр өнгөтэй, Цаасан хайрцаг гэх мэтийг хийх нарийн амсартай/ 3.Хуванцар, гялгар уут /ногоон өнгөтэй, ундааны сав, лааз хийх боломжтой дугуй амсартай/ гэсэн 3 төрлийн тасалгаатай, энгийн хог хаягдал хийх боломжгүй, авахад хялбар хаалгатай байх, хаалга нь дахивар ачих байгууллага л нээж хаах боломжтой цоожтой, Дахивар хогоо хийх амсар нь бүх насны хүн хүрч хийх боломжтой байдлаар шаттай.
	Өнгө	Их бие саарал, Дахивар хийх 3 хэсэг нь олон улсын стандартын дагуу ногоон, улбар шар, цэнхэр өнгөтэй.

	Ангилан ялгах нэр, таних тэмдэг	Хог хаягдлыг ангилан ялгах тасалгаа бүрт 20х30см хэмжээтэй таних тэмдэг бүхий нар салхинд гандаж бүдэгрэхгүй, зураг, нэр заавар байршуулсан байна. Хогийн сав нь тусгай мэдрэгчтэй, Хүн ойртоход дахивраа цуглуулж саванд хийж байгаад нь талархсан болон хог хаягдлаа ангилан ялгах зааварчилгаа өгдөг дуу хураагуурт бичигдсэн мэдээлэл дуугардаг байна.
	Үнэ	4.000.000 төгрөг

Дахивар цуглуулах сав буюу 1 ангилан ялгах хогийн сав хийх зардал

№	Бараа материалын нэр	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт /төг/
1	2х4 квадрат төмөр	60м	6000	360.000
2	4*4 квадрат төмөр	30 м	9000	270.000
3	Лист төмөр	12 ш	140.000	1.680.000
4	Будаг /ногоон, улбар шар, цэнхэр/	9 литр	10.000	90.000
5	Нугас	10 ш	4.000	40.000
6	Бариул	3 ш	10.000	30.000
7	Түгжээ	3 ш	10.000	30.000
8	Электрод	боод	35.000	35.000
9	Төмөр тор	2ш	150.000	300.000
10	Тасдагчны ир	1боод	15.000	15.000
11	Тээврийн зардал	3 удаа	50.000	150.000
12	Дуут зааварчилгаа өгөх төхөөрөмж	10 /1 запас/	100.000	1.000.000
13	Нийт дүн /төг/			4.000.000

Нийт тооцоо

№	Байршил	Үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	9	4.000.000	36.000.000

Загвар зураг